



## НИЙСЛЭЛИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2021 оны 02 сарын 04 өдөр

Дугаар А/05

Улаанбаатар хот

Дунд хугацааны стратеги  
төлөвлөгөө батлах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 1.10, Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 216 дугаар тогтоол, Монгол Улсын Засгийн газрын хэрэг эрхлэх газрын даргын 2020 оны 100 дугаар тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газрын 2021-2024 он хүртэлх үйл ажиллагааны дунд хугацааны стратеги төлөвлөгөө”-г хавсралтаар баталсугай.

2. Стратеги төлөвлөгөөний арга зам, зорилтот түвшинг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийг жил бүрийн төсөвт тусган, явцын үр дүнг тайлагнаж ажиллахыг Санхүү, аж ахуйн хэлтэс /Ц.Алтангэрэл/-т даалгасугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргааны асуудал хариуцсан орлогч дарга /Ш.Алтангэрэл/-д даалгасугай.

ДАРГА



Б. МӨНХБАТ

15  
Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газрын  
даргын 2021 оны 02 сарын 04-ны өдрийн  
Д/05 дугаар тушаалын хавсралт



# ДУНД ХУГАЦААНЫ СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨ /2021-2024 ОН/

Улаанбаатар хот

2021 он

**АГУУЛГА**

НЭГ. СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОВСРУУЛАХ ЕРӨНХИЙ ЗҮЙЛ ..... 2

ХОЁР. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ ..... 2

ГУРАВ. МАНДАТЫН ШИНЖИЛГЭЭ ..... 4

ДӨРӨВ. АЛСЫН ХАРАА ..... 14

ТАВ. ЭРХЭМ ЗОРИЛГО ..... 14

ЗУРГАА. ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭ ..... 14

ДОЛОО. СТРАТЕГИЙН ЗОРИЛГО ..... 19

НАЙМ. СТРАТЕГИЙН ЗОРИЛГО БА БҮТЦИЙН УЯЛДАА, ЗУРАГЛАЛ ..... 24

## СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨ 2021-2024 ОН

### НЭГ. СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОВСРУУЛАХ ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

Ирээдүйд хүрэх түвшин, тэр түвшинд хүрэх арга замуудаа зөв тодорхойлж, үйл ажиллагааны гүйцэтгэлийг төлөвлөгөөний дагуу хангаж чадсан тэр байгууллага хэрэглэгчиддээ үнэлэгдэн амжилттай ажиллаж, урт хугацааны туршид оршин тогтнох боломжтой билээ. Өөрөөр хэлбэл, стратеги төлөвлөгөө боловсруулж, төлөвлөгөөний дагуу үйл ажиллагаа явуулахгүйгээр ямарваа байгууллага үйл ажиллагаагаа оновчтой зохион байгуулж, өмнөө тавьсан зорилгодоо хүрэх боломжгүй юм.

Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газрын 2021-2024 он хүртэлх үйл ажиллагааны дунд хугацааны стратеги төлөвлөгөө боловсруулах болсонтой холбогдуулан "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар Хотын захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн баримт бичгүүдэд тулгуурласан шинэ стратеги төлөвлөгөөг боловсруулж байна.

### ХОЁР. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

Аливаа байгууллагын ажилчдын идэвх, санаачлага, бүтээлч байдал, чин эрмэлзлийг дэмжиж, хөгжлийн төлөөх тэдний оролцоог нэгтгэн зангидах замаар хөгжлийн бодлого, төлөвлөгөө биелэлээ олж байдаг. Байгууллагын ажилчдын хөгжлийн төлөөх оролцооны нэг хэлбэр бол тэдний оролцоотойгоор байгууллагын стратеги төлөвлөгөөг боловсруулж, хэрэгжүүлэх явдал мөн. Иймд Нийслэлийн хөрөнгө оруулалтын газрын өнөөгийн төлөв байдалд дүн шинжилгээ хийж, стратегийн үндэслэл, алсын хараа, эрхэм зорилго, стратегийн болон үйл ажиллагааны зорилтууд гарах үр дүн, хэрэгжүүлэх арга механизмыг байгууллагын стратеги төлөвлөгөөгөөр тодорхойлсон.

**Үндсэн зарчим.** Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газрын 2021-2024 он хүртэлх үйл ажиллагааны стратеги төлөвлөгөөг боловсруулахад дараах зарчмуудыг баримталсан болно. Үүнд:

- Байгууллагын хүний нөөц, чадавхийн давуу талд тулгуурлахын зэрэгцээ, сул тал, учирч болох эрсдлээс урьдчилан сэргийлэх асуудлыг төлөвлөгөөнд тусгагдсан аль ч асуудлын хувьд харгалзан үзэх,
- Ажилтан ажиллагсдын бүтээмжийг нэмэгдүүлэх замаар байгууллагын үйлчилгээний хүртээмж, чанарыг дээшлүүлэх,
- Гадаад хүчин зүйлсийн боломжийг зөв ашиглах.

**Боловсруулсан аргачлал.** Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн 100 тоот тушаалын хавсралт 1, 2 – т заасан аргачлалаар Байгууллагын стратеги төлөвлөгөө боловсруулсан болно.

**Зураг 1. Стратеги төлөвлөгөөг боловсруулсан арга зүйн дараалал**

Бодлогын бичиг баримтуудад уялдуулан байгууллагын үйл ажиллагааны стратеги зорилтуудыг үндсэн чиглэлийн дагуу тодорхойлж боловсруулсан.



**Зохион байгуулалтын арга хэмжээ**

Газрын даргын 2020 оны 09 дүгээр сарын 14-ний өдрийн А/73 тоот тушаалын дагуу Байгууллагын 4 жилийн стратеги төлөвлөгөөг дараах ажлын хэсгийн бүрэлдэхүүнтэй боловсруулсан. Үүнд:

**Дарга:** -Төлөвлөлтийн асуудал хариуцсан орлогч дарга

**Гишүүд:**  
-Захиргааны хэлтсийн дарга  
-Санхүү аж ахуйн хэлтсийн дарга  
-Барилга захиалагчийн хэлтсийн дарга  
-Зураг төслийн хэлтсийн дарга  
-Хууль дотоод хяналтын хэлтсийн дарга  
-Мэдээлэл технологийн хэлтсийн дарга

**Нарийн бичгийн дарга:** -Төлөвлөлт судалгааны хэлтсийн дарга

**Зураг 2. Стратеги төлөвлөгөө боловсруулах ажлын хэсгийн бүрэлдэхүүн**



Стратеги төлөвлөгөө боловсруулах ажлын хэсэг нь байгууллагын өнөөгийн байдалд дүн шинжилгээ хийх, стратеги төлөвлөгөөний зорилго, зорилт, үндэслэлийг тодорхойлох зорилгоор ажлын хэсгийн хурлыг 3 удаа зохион байгуулж боловсруулсан.

**ГУРАВ. МАНДАТЫН ШИНЖИЛГЭЭ**

**Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газрын чиг үүрэг, зохион байгуулалт**

Манай газар нь улс, нийслэл, орон нутгийн хөгжлийн сан болон бусад хөрөнгөөр нийслэлд хэрэгжиж буй бүхий л төсөл, арга хэмжээнд захиалагчийн хяналтыг мэргэжлийн түвшинд хэрэгжүүлдэг орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар юм. 2010 онд Нийслэлийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 49 дүгээр тогтоолоор Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар нэртэйгээр үйл ажиллагаа явуулж эхэлсэн.

**Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газрын үйл ажиллагааны чиглэл:**

- ✓ Хөрөнгө оруулалтын судалгаа шинжилгээний үр дүнгийн саналаа холбогдох газар хүргүүлэх, хамтран ажиллах
- ✓ Зураг төслийг хянах, түүний хэрэгжилтийн ажлыг зохион байгуулах, зураг төсвийн ажилд гэрээний үндсэн дээр хяналт тавих
- ✓ Улс, нийслэлийн төсөв, гадаадын хөрөнгө оруулалт, зээл тусламж бусад хөрөнгөөр барилга байгууламж шинээр барих, өргөтгөх, шинэчлэн засварлах үйл ажиллагаанд гэрээний үндсэн дээр гүйцэтгэлийн хяналт тавих
- ✓ Захиалагчийн хяналтыг мэргэжлийн түвшинд зохион байгуулах, шинэ барилга байгууламж болон их засварын ажлын техникийн бичиг баримт, ажлын гүйцэтгэл, санхүүгийн бичиг баримтын бүрдлийг шалган заавар өгч, хянаж баталгаажуулах
- ✓ Хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний ил, далд ажлын актыг баталгаажуулах, материалын стандартыг хангуулах, гүйцэтгэлийг хянаж батлах, санхүүжүүлэх, объектыг ашиглалтанд оруулах
- ✓ Төсвийн тухай хуулийн дагуу хөрөнгө оруулалтыг санхүүжүүлэх, удирдлага зохион байгуулалтаар хангах, гүйцэтгэлд хяналт тавих, бүртгэх, тайлагнах, үр ашгийг нэмэгдүүлэх санал боловсруулж хэрэгжүүлэх
- ✓ Барилга угсралтын ажилд шинэ техник, технологи нэвтрүүлэх талаар санаачлагатай ажиллаж хөрөнгө оруулалтын үр ашгийг дээшлүүлэх
- ✓ Хууль тогтоомжоор хориглоогүй бусад үйл ажиллагаа эрхлэх

**Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газрын дүрмээр хүлээсэн дараах чиг үүрэг:**

- ✓ Улс, Нийслэлийн төсөв, гадаадын хөрөнгө оруулалт, зээл тусламжийн хөрөнгөөр барилга байгууламж шинээр барих, өргөтгөх, шинэчлэн засварлах үйл ажиллагаанд гэрээний үндсэн дээр гүйцэтгэлийн хяналт тавих

- ✓ Захиалагчийн хяналтыг мэргэжлийн түвшинд зохион байгуулах, шинэ барилга байгууламж болон их засварын ажлын техникийн бичиг баримт, ажлын гүйцэтгэл, санхүүгийн бичиг баримтын бүрдлийг шалган заавар өгч, хянаж баталгаажуулах
- ✓ Хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний ил далд ажлын актыг баталгаажуулах, материалын стандартыг хангуулах, гүйцэтгэлийг хянаж батлах, санхүүжүүлэх, объектыг ашиглалтанд оруулах
- ✓ Барилга угсралтын ажилд шинэ техник, технологи нэвтрүүлэх талаар санаачлагатай ажиллаж хөрөнгө оруулалтын үр ашгийг дээшлүүлэх
- ✓ Зураг төслийг хянах, түүний хэрэгжилтийн ажлыг зохион байгуулах, зураг төсвийн ажилд гэрээний үндсэн дээр хяналт тавих
- ✓ Төсвийн тухай хуулийн дагуу хөрөнгө оруулалтыг санхүүжүүлэх, удирдлага зохион байгуулалтаар хангах, гүйцэтгэлд хяналт тавих, бүртгэх, тайлагнах, үр ашгийг нэмэгдүүлэх санал боловсруулж хэрэгжүүлэх
- ✓ Хөрөнгө оруулалтын судалгаа шинжилгээний үр дүнгийн саналаа холбогдох газар хүргүүлэх, хамтран ажиллах
- ✓ Хувийн хэвшлийн байгууллагуудтай хамтарч ажиллах
- ✓ Хөрөнгө оруулалтын нэгдсэн бүртгэлийн программ хангамжийг хөгжүүлэх, бусад газар хэлтэс, агентлаг, хөрөнгө оруулагчдын мэдээллийн нэгдсэн сан үүсгэсэн байдал

**Байгууллагын уриа:** Зөв төлөвлөө, Төгс гүйцэтгэе

2019 оны 07 дугаар сарын 31-ний өдөр батлагдсан Нийслэлийн Засаг даргын А/771 тоот захирамжаар газрын дүрэм, бүтэц, орон тоогоор үйл ажиллагаа явуулж байна. Үүнд:

№	Хэлтэс	Орон тоо
1	Удирдлага	5
2	Захиргааны хэлтэс	9
3	Хууль, дотоод хяналтын хэлтэс	6
4	Мэдээллийн технологийн хэлтэс	6
5	Барилга захиалагчийн хэлтэс	29
6	Зураг төслийн хэлтэс	9
7	Санхүү, аж ахуйн хэлтэс	17
8	Төлөвлөлт судалгааны хэлтэс	12
	<b>Нийт</b>	<b>93</b>

Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газрын даргын 2019 оны 09 дүгээр сарын 06-ны өдрийн А/43 дугаар тушаалаар хэлтсүүдийн үндсэн чиг үүргийг баталсан. Үүнд:

**Төлөвлөлт судалгааны хэлтсийн чиг үүрэг:**

- Нийслэлийн хэмжээний хөрөнгө оруулалтын хэрэгцээг судлан, дүн шинжилгээ хийж үр дүнгийн саналаа холбогдох газруудад хүргүүлэх;
- Шаардлагатай хөрөнгө оруулалтын төсөл, хөтөлбөрүүдийг боловсруулах;
- Хөрөнгө оруулалтын ажлын эдийн засгийн зардал, үр ашиг, хэтийн хөрөнгө оруулалтын тооцоог боловсруулах, хөрөнгө оруулалтын тайлан бэлтгэх;
- Газарт хэрэгжиж буй төсөл, арга хэмжээний ажлын мэдээг салбар, дүүрэг, ажлын чиглэлээр гаргаж удирдлагад танилцуулах;
- Монгол Улсын засгийн газрын бодлогын зорилтууд, үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний хэрэгжилтийг ханган биелэлт гаргах;
- Нийслэлийн засаг даргын захирамжийн биелэлт гаргах;
- НИТХ-ын тогтоол шийдвэр, бодлогын зорилтууд, төлөвлөгөөний биелэлтийг гаргах;

- Барилга байгууламж, инженерийн шугам сүлжээний ажлын хэрэгжилтын явцад тулгарсан асуудлыг судлаж холбогдох байгууллагуудад хандан хамтран шийдвэрлүүлэх;
- Гадны орнуудад амжилттай хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын төсөл хөтөлбөр, туршлага судлах;
- Гадаад харилцаатай холбоотой газрын үйл ажиллагааг төлөвлөх, зохион байгуулах;
- Бусад

#### **Зураг төслийн хэлтсийн чиг үүрэг:**

- Барилга байгууламжийн зураг төсөлд тавигдах шаардлагыг хангуулах, инженер хайгуулын судалгаа хийх, зураг төслийг үе шатны дагуу боловсруулах, зөвшилцөх, батлах, магадлал хийх, хадгалахтай холбоотой үйл ажиллагаанд захиалагчийн хяналтыг мэргэжлийн түвшинд хэрэгжүүлнэ.
- Барилга байгууламжийн техникийн нөхцөл авах, зураг төсөл боловсруулах үе шатны ажлууд, зураг төсөлд магадлал хийлгэх ажлыг зохион байгуулна.
- Төсөл арга хэмжээний бэлтгэл ажил болох газар түүнтэй холбогдох асуудлыг судлах, шийдвэрлүүлэх, газар ашиглалтын байдал, төлөвлөлтөд судалгаа хийх, газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд санал өгөх, мэдээллийн сан үүсгэх, хөтлөх;
- Хөрөнгө оруулалтын ажлын бэлтгэл болох зураг төсөл боловсруулах ажлын явцад инженерийн шугам сүлжээний трасс сонголт болон газар олголт, чөлөөлөх асуудлыг судлан холбогдох байгууллагуудад хандан хамтран шийдвэрлүүлэх;
- Зураг төслийн ажлыг гэрээт хугацаанд төлөвлөлт, техникийн норм стандартын дагуу гүйцэтгүүлж, төлөвлөгөөт хугацаандаа хэрэгжих нөхцөлийг бүрдүүлэхэд хяналт тавих;
- Зураг төсвийн ажлын техникийн бичиг баримт, ажлын гүйцэтгэл, санхүүгийн бичиг баримтын бүрдэлд мэргэжил арга зүйн заавар, зөвлөгөөг өгч, хянах
- Гүйцэтгэгч нь батлагдсан архитектур төлөвлөлт, зургийн даалгавар, тохижилтын ажлын төлөвлөлтийн даалгавар, техникийн нөхцөлөөс зөрүүтэй, холбогдох хууль тогтоомж, хүчин чадал, технологийн стандартын шаардлага хангаагүй, норм дүрмийг зөрчиж зураг төслийг чанаргүй гүйцэтгэж боловсруулсан тохиолдолд илэрсэн зөрчлийг арилгуулах, асуудлыг шийдвэрлүүлэх;
- Зургийн ажлын явцад батлагдсан зураг төслийн газар олголт, шугам сүлжээний трассын координат цэгүүдийг Нийслэлийн газрын албанд шалгуулан, бүртгүүлж, баталгаажуулах;
- Хэлтсийн үйл ажиллагааны төлөвлөгөөний тухайн оны биелэлтийг гаргах;
- Бусад

#### **Барилга захиалагчийн хэлтсийн чиг үүрэг:**

- Газрын хэмжээнд хэрэгжиж буй Барилга байгууламж болон инженерийн шугам сүлжээ, их засварын ажлуудын гүйцэтгэлд Барилгын тухай хууль, Захиалагчийн дүрэм болон бусад холбогдох хуульд заасан чиг үүргээр захиалагчийн техник хяналтыг мэргэжлийн түвшинд хэрэгжүүлэх;
- Барилга байгууламж болон инженерийн шугам сүлжээ, их засварын ажлуудын гүйцэтгэгчээр сонгон шалгарсан байгууллагатай захиалагчийн байгуулсан гэрээ болон бусад холбогдох баримт бичгийг хүлээн авч Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль, Сангийн сайдын 415 дугаар тушаалаар батлагдсан Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, санхүүжилт, хяналт, тайлагналтын журам болон магадлалаар батлагдсан зураг төсвийн дагуу хянах, шаардлагатай тохиолдолд захиалагчид буцаах;



- Түлхүүр гардуулах гэрээний нөхцөлтэй ажлуудад Зураг төсвийн хэлтэстэй хамтарч ажиллан, шаардлага хангасан зураг төсвийг хүлээн авах;
- Барилга байгууламж болон их засварын ажлын техникийн бичиг баримт, ажлын гүйцэтгэл, санхүүгийн бичиг баримтын бүрдэлд мэргэжил арга зүйн заавар, зөвлөгөөг өгч, хянаж, баталгаажуулах ;
- Барилгын үйл ажиллагаанд холбогдох норм, нормативын баримт бичгийг баримтлан, эрүүл ахуй, хөдөлмөрийн аюулгүй байдлын нөхцлийг хөнхцлийг хангах арга хэмжээг гүйцэтгэгч байгууллагатай хамтарч төлөвлөн хэрэгжүүлэх ;
- Барилгын ажлын гүйцэтгэл, санхүүжилтийг гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээний дагуу ажлын гүйцэтгэлийн үе шат бүрээр холбогдох хууль дүрэм журмын дагуу хянаж баталгаажуулах;
- Ажилд гүйцэтгэлийн явцад гарсан өөрчлөлтийг магадлан тогтоох, шаардлагатай тохиолдолд төсвийн төсөл, төсвийн тодотголд санал оруулах
- Ажлын зураг төсөлтэй барилга байгууламжийн ажилд зохиогчийн хяналтын гэрээг байгуулж, хяналт хийлгэх, хөндлөнгийн лабораторын шинжилгээгээр материал, хийц, бүтээц, эдлэхүүний чанар, аюулгүй байдлын техникийн үзүүлэлтүүдийг тодорхойлуулах;
- БУА-ыг бодит гүйцэтгэлийн дагуу координат цэгүүд болон шугам сүлжээний трассаар Нийслэлийн хот байгуулалт, хөгжлийн газрын Хот байгуулалт, газрын кадастр мэдээллийн хэлтэст бүртгүүлэх;
- Ажлын зураг болон угсралтын ажилд алдаа, дутагдал гарсан тохиолдолд Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газраар дүгнэлт гаргуулж, зураг төсөвт магадлал хийлгэх;
- Гүйцэтгэгч технологийн горим, батлагдсан зураг, техникийн нөхцөл зөрчиж чанаргүй гүйцэтгэсэн тохиолдолд илэрсэн зөрчлийг арилгуулах, техникийн шийдэл гаргах болон буруутай этгээдүүдийн зардлаар ажлыг дахин хийлгэж хохирлыг барагдуулах, шаардлагатай тохиолдолд нөхөн төлбөр тавих, гэрээг цуцлах асуудлыг холбогдох албан тушаалтанд тавьж шийдвэрлүүлэх;
- Барилга байгууламж, инженерийн шугам сүлжээний угсралтын ажлын ашиглалтад оруулах комиссын үйл ажиллагааг гүйцэтгэгчтэй хамтран зохион байгуулах, барилга байгууламжийг ашиглагчид хүлээлгэн өгөх;
- Газрын даргын тушаалаар батлагдсан үнэлгээний хороодын ажлын баримт бичгийн бүрдүүлэлт /эрх шилжсэн захирамж, газрын даргын бүрэлдэхүүн томилсон тушаал, үнэлгээний хороонд ажиллахыг зөвшөөрсөн мэдүүлэг, хурлын тэмдэглэл, зөвлөмж/-ийн мэдээллийн сан хөтлөх, архивын нэгж болгон архивт хүлээлгэх өгөх;
- Дууссан барилга байгууламжийг Нийслэлийн өмчид бүртгүүлэх, архивын нэгж болгон архивт хүлээлгэх өгөх;
- Барилга байгууламжийн чанарын баталгаат хугацааны техник хяналт хийн, гарсан зөрчил, дутагдлыг арилгах;
- Бусад

#### **Санхүү, аж ахуйн хэлтсийн чиг үүрэг:**

- Газрын санхүүгийн үйл ажиллагааг Нягтлан бодох бүртгэлийн хууль, тогтоомжид нийцүүлэн, хэвийн үр ашигтай явуулах, удирдан зохион байгуулах, мөнгөний урсгалыг төлөвлөж зохицуулах, тайлан тэнцлээр гарсан үр дүнг тайлагнах, өмчийн зөрчилгүй байх, эд хөрөнгийн хадаглалт хамгаалалтад бүртгэлээр тавих хяналтыг сайжруулах ,төсвийн хуулийн дагуу хөрөнгө оруулалтыг санхүүжүүлэх, мөн удирдлагыг санхүүгийн мэдээллээр тогтмол хангах;
- Санхүүгийн үйл ажиллагаа болон хөрөнгө оруулалт, санхүүжилтийн явцтай холбоотой тайлан тэнцлийг хуулийн хугацаанд сар бүр гаргах
- Өмч, хөрөнгийн бүрэн бүтэн байдал, ашиглалтад хяналт тавих;

- Төсөл, арга хэмжээний барилга угсралтын болон зураг төслийн ажлын гүйцэтгэлийг хянах, баталгаажуулах, санхүүжүүлэх;
- Контракт гэрээ, эдийн засгийн үр ашигийг нэмэгдүүлэх зорилтод төлөвлөгөөний биелэлтийг хангаж ажиллах, тайлагнах;
- Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах
- Харьяа болон гадны байгууллагуудтай хуульд нийцүүлэн худалдах, худалдан авах гэрээ хийх, сургалт зохион байгуулах
- Бусад

#### **Захиргааны хэлтсийн чиг үүрэг:**

- Газрын өдөр тутмын хэвийн үйл ажиллагааны нөхцөлийг бүрдүүлэх;
- Үйл ажиллагааны нэгдмэл байдал, дотоод зохион байгуулалт, үндсэн зорилт, чиг үүргийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;
- Ажилтантай хөдөлмөрийн гэрээ байгуулах үйл ажиллагааг зохион байгуулах;
- Хөдөлмөрийн дотоод журам, ажлын байрны тодорхойлолтод заагдсан чиг үүрэг, холбогдох дүрэм, журмын хэрэгжилтэд хяналт тавих;
- Ажилтнуудын дэг журам, сахилга, хариуцлага, ёс зүйн хэм хэмжээнд хяналт тавих, сахиулах арга хэмжээ авах;
- Ажилтныг мэргэшүүлэх, давтан сургах болон нийгмийн асуудлыг шийдвэрлүүлэх ажлыг удирдан зохион байгуулах;
- Ажилтныг шагнал урамшуулалд тодорхойлох, сахилгын арга хэмжээ авахуулах шийдвэрлүүлэх ажлыг зохион байгуулах;
- Захиргаа, хүний нөөц, архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагааг эрхлэн явуулах;
- Сургалт, семинар, олон нийтийн арга хэмжээг зохион байгуулах;
- Ажилтны ажлын гүйцэтгэлийг үнэлж дүгнэх;
- Гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг хангуулах;
- Ёс зүйн дүрмийн хэрэгжилтийг хангуулах;
- Газрын даргын зөвлөлийн хурал болон шуурхай хуралдааны үйл ажиллагааг зохион байгуулах;
- Үйлчилгээний нэгдсэн төвөөр дамжин ирсэн баримт бичгүүдийг хүлээн авах, бүртгэлжүүлэх;
- Бусад

#### **Хууль дотоод хяналтын хэлтсийн чиг үүрэг:**

- Нийслэлийн нийгэм эдийн засгийн зорилт, Нийслэлийн Засаг даргын мөрийн хөтөлбөрийн холбогдох заалтын хэрэгжилтийг хангуулах үйл ажиллагаанд батлагдсан журмын хүрээнд хяналт тавьж газрын даргыг мэдээллээр хангах, хэрэгжилт хангалтгүй байгаа ажлуудыг эрчимжүүлэх талаар санал зөвлөмж өгөх;
- Газрын хэмжээнд хэрэгжиж байгаа төсөл арга хэмжээний зураг төсөл боловсруулах, барилга угсралтын ажлын явцын гүйцэтгэлд захиалагчийн хяналтыг тодорхой үе шаттайгаар оновчтой хэрэгжүүлж байгаа эсэхэд дотоод хяналтын журамд заасан болон тодорхой чиглэлтэй батлагдсан удирдамж төлөвлөгөөтэйгээр хяналт хийх, гарсан зөрчил дутагдлыг арилгуулах талаар заавар зөвлөмж өгөх, газрын даргыг мэдээллээр хангах;
- Газрын үйл ажиллагаа холбогдох хууль, тогтоомжид нийцсэн эсэхэд хяналт тавих, илэрсэн зөрчлийг арилгуулах талаар санал, зөвлөмж, дүгнэлт гаргах;
- Газрын үйл ажиллагаатай холбоотой учирч болзошгүй аливаа эрсдлээс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулан газрын даргыг үнэн зөв мэдээллээр тогтмол хангах;


- Дотоодод мөрдөгдөх дүрэм, журам боловсруулах, газрын даргын тушаал, газрын үйл ажиллагаатай холбоотой гэрээ, эрх зүйн баримт бичгүүдийн хууль зүйн үндэслэлийг хянах, заавар, зөвлөгөө өгөх;
- Газрын даргаас олгосон итгэмжлэлийн үндсэн дээр газрыг холбогдох хууль, шүүхийн байгууллагад төлөөлөх;
- Зохиогчийн хяналтын гэрээг хянаж, бүртгэл хөтлөх;
- Газрын нийт ажилтны албан үүрэгтэй холбоотой асуудлаар тухай бүр хууль зүйн мэдээллээр хангах, эрх зүйн зөвлөгөө, туслалцаа үзүүлэх;
- Гэрээ дүгнэсэн протколыг хянах, гэрээт ажлыг хэрэгжүүлэх явцад үүссэн асуудлаар хууль, эрх зүйн зөвлөгөө өгөх;
- Нийслэлийн Засаг дарга болон бусад эрх бүхий албан тушаалтантай газрын даргын байгуулсан контракт гэрээний хэрэгжилтэнд хяналт тавих;
- Дотоод хяналтын явцад илэрсэн зөрчлийг арилгах, урьдчилан сэргийлэх талаар мэргэжил арга зүйн зөвлөгөөг удирдлагад өгөх
- Нийт ажилтнуудаас хууль эрх зүйн мэдлэг, мэргэжлийн түвшин тогтоох шалгалтыг удирдан зохион байгуулах, дүгнэх, дүнг удирдлагад тайлагнах;
- Газрын даргын тушаалын дагуу байгуулагдсан ажлын хэсэг, комисс болон томилгоот ажлыг гүйцэтгэх;
- Бусад

**Мэдээллийн технологийн хэлтсийн чиг үүрэг:**

- Газрын хэмжээнд хэрэгжиж буй төсөл, арга хэмжээний явц, үр дүнг хэвлэл мэдээллийн хэрэгсэл телевиз радио, олон нийтийн социал сүлжээгээр сурталчлах, олон нийттэй харилцах;
- Хурал зөвлөгөөн, сургалт, олон нийтийн арга хэмжээний явцыг зурагжуулан баримтжуулж, эх бэлтгэл /брошур, баннер, постер/ хийж мэдээ мэдээлэл бэлтгэн цаг алдахгүй нийтлэх;
- Олон нийтийн мэдээллийн хэрэгслээр буруу ташаа мэдээллийг шуурхай судалж, залруулах, үнэн зөв хариу өгөх ажлыг зохион байгуулах;
- Нийслэлийн хэмжээнд хэрэглэгддэг нэгдсэн системүүд болох [Erp.ulaanbaatar.mn](http://Erp.ulaanbaatar.mn), [open.ulaanbaatar.mn](http://open.ulaanbaatar.mn), [Shilendans.gov.mn](http://Shilendans.gov.mn), [ublegal.mn](http://ublegal.mn), [tender.gov.mn](http://tender.gov.mn), газрын хэмжээнд хэрэглэгддэг бүртгэл мэдээллийн систем [investpro.ub.gov.mn](http://investpro.ub.gov.mn), [invest.ub.gov.mn](http://invest.ub.gov.mn) сайтуудын хэвийн үйл ажиллагааг хангах;
- Газрын үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг хангах;
- Газрын вэб сайтын хэвийн үйл ажиллагааг хангах, хөгжүүлэх;
- Газрын серверийн тохиргоо болон холболтыг хариуцан сервер болон хадгалах тоног төхөөрөмжийн шинэчлэл, хүчин чадлыг нэмэгдүүлэх талаар санал боловсруулах, орчин үеийн техникийн дэвшил, шинэ технологийг ашиглалтыг үйл ажиллагаанд нэвтрүүлэх;
- Үйл ажиллагааны дотоод гадаад сүлжээний гүйцэтгэлийг хянаж, нэмэгдүүлэх, Сүлжээний асуудлууд ба сул зогсолтыг шийдвэрлэх;
- Цахим мэдээллийн нэгдсэн сан, мэдээллийн нэгдсэн сүлжээ, мэдээллийн системийн хэвийн үйл ажиллагаа, аюулгүй байдлыг хариуцах, мэдээллийн сангийн уялдаа холбоог хангах;
- Газрын бүртгэл мэдээллийн системийн хэвийн үйл ажиллагааг хангах хянах;
- Техник хангамж, мэдээллийн сүлжээ, техник хэрэгслийн элэгдэл хорогдол, гэмтэл саатал, доголдлоос сэргийлэх, хэвийн ажиллагааг хангах, гэмтэл, саатлыг тухай бүр түргэн шуурхай засварлах арга хэмжээ авах;
- Газрын нийт албан хаагчдын компьютерт мэргэжлийн болон хэрэглээний программ суулгах, заавар зөвлөгөө өгч, хэвийн үйл ажиллагааг хангах;
- Бусад


Хүний нөөцийн өнөөгийн байдал: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар батлагдсан орон тоо, ажлын байрны тодорхойлолтын дагуу нийт 93 ажилтан, албан хаагчтай хөдөлмөрийн гэрээ байгуулан үйл ажиллагаагаа явуулсан байна.

#### Ажилчдын ажилласан жил:



Байгууллагын хэмжээнд ажиллаж байгаа ажилчдыг нийт ажилласан жилээр нь авч үзвэл:  
-1-5 жил ажиллаж байгаа 23 ажилтан - 25%  
-6-10 жил ажиллаж байгаа 34 ажилтан - 37%  
-11-15 жил ажиллаж байгаа 17 ажилтан - 17%  
-16-20 жил ажиллаж байгаа 8 ажилтан - 8%  
-21-ээс дээш жил ажиллаж байгаа 10 ажилтан - 11% ийг тус тус эзэлж байна.

#### Ажилчдын насны ангилал:



Байгууллагын нийт ажилчдыг насны ангилалаар нь авч үзвэл:  
-20-30 насны 22 ажилтан – 23%  
-31-40 насны 49 ажилтан – 53%  
-41-50 насны 13 ажилтан – 14%  
-51-с дээш насны 9 ажилтан – 10%-ийг тус тус эзэлж байна. Ажилчдын 59% нь буюу 55 эрэгтэй, 41% нь буюу 38 эмэгтэйчүүд байна.

#### Ажилчдын зэрэг, цол, мэргэшлийн байдал:

- Монгол улсын зөвлөх инженер – 6
- Зөвлөх эдийн засагч – 1
- Доктарант – 2
- Магистр – 25
- Магистрант – 2
- Мэргэшсэн инженер – 19
- Мэргэшсэн төсөвчин – 11
- Мэргэшсэн нягтлан бодогч – 1
- Мэргэшсэн эдийн засагч – 3
- Мэргэшсэн дотоод аудитор – 2

Хүний нөөцийн удирдлага: Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газрын даргын 2018 оны 02 дугаар сарын 12-ны өдрийн А/17 дугаар тушаалаар "Хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөр"-ийг батлан хэрэгжүүлсэн. Хөтөлбөрийг 5 зорилтын хүрээнд боловсруулан 2018-2020 онд мөрдөн ажилласан байна.

Байгууллагын стратеги төлөвлөгөө боловсруулж байгаатай холбогдуулан 2021-2024 оны Хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөрийг шинэчлэн боловсруулах ажил хийгдэж байна.

**Мандатын шинжилгээ**

Салбарын үйл ажиллагаанд мөрдөгдөж байгаа хуулийн тоо		31
Үүнээс:	Тухайн салбарын хуулиуд	<ol style="list-style-type: none"> <li>1. Барилгын тухай хууль</li> <li>2. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль</li> <li>3. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль</li> </ol>
	Нийтлэг мөрддөг хуулиуд	<ol style="list-style-type: none"> <li>1. Иргэний хууль</li> <li>2. Төсвийн тухай хууль</li> <li>3. Компанийн тухай хууль</li> <li>4. Хөдөлмөрийн тухай хууль</li> <li>5. Хот байгуулалтын тухай хууль</li> <li>6. Байгууллагын нууцын тухай хууль</li> <li>7. Газрын тухай хууль</li> <li>8. Шилэн дансны тухай хууль</li> <li>9. Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хууль</li> <li>10. Татварын ерөнхий хууль</li> <li>11. Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль</li> <li>12. Иргэдээс төрийн байгууллага албан тушаалтанд өргөдөл гомдол гаргах, түүнийг хянан шийдвэрлэх тухай хууль</li> <li>13. Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль</li> <li>14. Хөрөнгө оруулалтын тухай хууль</li> <li>15. Концессын тухай хууль</li> <li>16. Хот суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хууль</li> <li>17. Авлигын эсрэг хууль</li> <li>18. Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль</li> <li>19. Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хууль</li> <li>20. Инновацын тухай хууль</li> <li>21. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль</li> <li>22. Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль</li> <li>23. Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хууль</li> <li>24. Эрчим хүчний тухай хууль</li> <li>25. Захиргааны ерөнхий хууль</li> <li>26. Харилцаа холбооны тухай хууль</li> <li>27. Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль</li> <li>28. Гамшгаас хамгаалах тухай хууль</li> </ol>
Ерөнхий чиг үүрэг-1: Байгууллагын дотоод болон гадаад бүхий л үйл ажиллагаанд чанарын удирдлагын тогтолцоог нэвтрүүлэх, хууль, эрх зүй, дүрэм журам, стандартыг мөрдөж ажиллах		
Үндсэн чиг үүрэг	Дэд чиг үүрэг	Хамтран хэрэгжүүлэх чиг үүрэг, оролцогчид
ҮЧҮ-1: Газрын үйл ажиллагаатай холбоотой учирч болзошгүй аливаа эрсдлээс хамгаалах	<p>Газрын хэмжээнд хэрэгжиж байгаа төсөл арга хэмжээний зураг төсөл боловсруулах, барилга угсралтын ажлын явцын гүйцэтгэлд захиалагчийн хяналтыг тодорхой үе шаттайгаар оновчтой хэрэгжүүлж байгаа эсэхэд хяналт хийх, гарсан зөрчил дутагдлыг арилгуулах талаар зөвлөмж өгөх, газрын даргыг мэдээллээр хангах;</p> <p>Газрын даргаас олгосон итгэмжлэлийн үндсэн дээр газрыг холбогдох хууль, шүүхийн байгууллагад төлөөлөх;</p> <p>Барилга угсралтын ажлын болон зөвлөх үйлчилгээний гэрээний бүрдлийг хянах, хэрэгжилтийг дүгнэх,</p>	Яам, НЗДТГ болон харъяа газар агентлагууд

	хэрэгжилтийн явцад үүссэн зөрчлийг илрүүлэх, илрүүлсэн зөрчлийг арилгуулах.	
	Газрын даргын тушаалын дагуу байгуулагдсан ажлын хэсэг, комисс болон томилгоот ажлыг гүйцэтгэх	
Ерөнхий чиг үүрэг-2: Байгууллагын үйл ажиллагаа, үйлчилгээний чанар, хүртээмж, үр ашгийг дээшлүүлэх, хүний нөөцийг чадавхжуулах		
ҮЧҮ-2: Үйл ажиллагааны нэгдмэл байдлыг зохион байгуулах, өдөр тутмын хэвийн үйл ажиллагаа явагдах нөхцлийг бүрдүүлэх	Ажилтантай хөдөлмөрийн гэрээ байгуулах үйл ажиллагааг зохион байгуулах;	Яам, НЗДТГ болон харъяа газар агентлагууд
	Хөдөлмөрийн дотоод журам, ажлын байрны тодорхойлолтод заагдсан чиг үүрэг, холбогдох дүрэм, журмын хэрэгжилтэд хяналт тавих;	
	Ажилтнуудын дэг журам, сахилга, хариуцлага, ёс зүйн хэм хэмжээнд хяналт тавих, сахиулах арга хэмжээ авах;	
	Захиргаа, хүний нөөц, архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагааг эрхлэн явуулах;	
	Ажилтны ажлын гүйцэтгэлийг үнэлж дүгнэх, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг хангуулах;	
Ерөнхий чиг үүрэг-3: Төсвийн хөрөнгө оруулалтыг оновчтой, үр дүнтэй төлөвлөх, хөрөнгө оруулалтын нэгдсэн мэдээллийн сан үүсгэх, хамтарч ажиллах		
ҮЧҮ-3: Нийслэлийн хэмжээний хөрөнгө оруулалтын хэрэгцээг судлан дүн шинжилгээ хийж үр дүнгийн саналаа холбогдох газруудад хүргүүлэх	Газарт хэрэгжиж буй төсөл, арга хэмжээний ажлын мэдээг салбар, дүүрэг, ажлын чиглэлээр гаргаж удирдлагад танилцуулах;	Яам, НЗДТГ болон харъяа газар агентлагууд
	Хөрөнгө оруулалтын ажлын эдийн засгийн зардал, үр ашиг, хэтийн хөрөнгө оруулалтын тооцоог боловсруулах, хөрөнгө оруулалтын тайлан бэлтгэх;	
	Шаардлагатай хөрөнгө оруулалтын төсөл, хөтөлбөрүүдийг боловсруулах;	
Ерөнхий чиг үүрэг-4: Зөвлөх үйлчилгээг мэргэжлийн өндөр түвшинд хүргэж бүтээн байгуулалтын чанарыг дээшлүүлэх		
ҮЧҮ-4: Барилга байгууламжийн зураг төсөлд тавигдах шаардлагыг хангуулах, инженер хайгуулын судалгаа хийх, зураг төслийг үе шатны дагуу боловсруулах, зөвшилцөх, батлах, магадлал хийх, хадгалахтай холбоотой үйл ажиллагаанд захиалагчийн хяналтыг мэргэжлийн түвшинд хэрэгжүүлнэ	Барилга байгууламжийн техникийн нөхцөл авах, зураг төсөл боловсруулах үе шатны ажлууд, зураг төсөлд магадлал хийлгэх ажлыг зохион байгуулах.	Яам, НЗДТГ болон харъяа газар агентлагууд
	Хөрөнгө оруулалтын ажлын бэлтгэл болох зураг төсөл боловсруулах ажлын явцад инженерийн шугам сүлжээний трасс сонголт болон газар олголт, чөлөөлөх асуудлыг судлан холбогдох байгууллагуудад хандан хамтран шийдвэрлүүлэх;	
	Зураг төслийн ажлыг гэрээт хугацаанд төлөвлөлт, техникийн норм стандартын дагуу гүйцэтгүүлж, төлөвлөгөөт хугацаандаа хэрэгжих нөхцөлийг бүрдүүлэхэд хяналт тавих;	
	Зураг төсвийн ажлын техникийн бичиг баримт, ажлын гүйцэтгэл, санхүүгийн бичиг баримтын бүрдэлд мэргэжил арга зүйн заавар, зөвлөгөөг өгч, хянах	
	Гүйцэтгэгч нь батлагдсан архитектур төлөвлөлт, зургийн даалгавар, тохижилтын ажлын төлөвлөлтийн даалгавар, техникийн нөхцөлөөс зөрүүтэй, холбогдох хууль тогтоомж, хүчин чадал, технологийн стандартын шаардлага хангаагүй, норм дүрмийг зөрчиж зураг төслийг чанаргүй гүйцэтгэж боловсруулсан тохиолдолд илэрсэн зөрчлийг арилгуулах, асуудлыг шийдвэрлүүлэх;	
Ерөнхий чиг үүрэг-5: Захиалагчийн хяналтыг мэргэжлийн өндөр төвшинд хүргэж бүтээн байгуулалтын чанарыг дээшлүүлэх		
	Барилга байгууламж болон инженерийн шугам сүлжээ, их засварын ажлуудын гүйцэтгэгчээр сонгон шалгарсан байгууллагатай захиалагчийн байгуулсан	

<p>ҮЧҮ-5: Газрын хэмжээнд хэрэгжиж буй Барилга байгууламж болон инженерийн шугам сүлжээ, их засварын ажлуудын гүйцэтгэлд Барилгын тухай хууль, Захиалагчийн дүрэм болон бусад холбогдох хуульд заасан чиг үүргээр захиалагчийн техник хяналтыг мэргэжлийн түвшинд хэрэгжүүлэх;</p>	<p>гэрээ болон бусад холбогдох баримт бичгийг хүлээн авч Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль, Сангийн сайдын 282 дугаар тушаалаар батлагдсан Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, санхүүжилт, хяналт, тайлагналтын журам болон магадлалаар батлагдсан зураг төсвийн дагуу хянах, шаардлагатай тохиолдолд захиалагчид буцаах;</p> <p>Түлхүүр гардуулах гэрээний нөхцөлтэй ажлуудад Зураг төсвийн хэлтэстэй хамтарч ажиллан, шаардлага хангасан зураг төсвийг хүлээн авах;</p> <p>Барилгын ажлын гүйцэтгэл, санхүүжилтийг гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээний дагуу ажлын гүйцэтгэлийн үе шат бүрээр холбогдох хууль дүрэм журмын дагуу хянаж баталгаажуулах;</p> <p>Ажлын зураг төсөлтэй барилга байгууламжийн ажилд зохиогчийн хяналтын гэрээг байгуулж, хяналт хийлгэх, хөндлөнгийн лабораторын шинжилгээгээр материал, хийц, бүтээц, эдлэхүүний чанар, аюулгүй байдлын техникийн үзүүлэлтүүдийг тодорхойлуулах;</p> <p>Ажлын зураг болон угсралтын ажилд алдаа, дутагдал гарсан тохиолдолд Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газраар дүгнэлт гаргуулж, зураг төсөвт магадлал хийлгэх</p> <p>Барилга байгууламж, инженерийн шугам сүлжээний угсралтын ажлын ашиглалтад оруулах комиссын үйл ажиллагааг гүйцэтгэгчтэй хамтран зохион байгуулах, барилга байгууламжийг ашиглагчид хүлээлгэн өгөх</p> <p>Дууссан барилга байгууламжийг Нийслэлийн өмчид бүртгүүлэх, архивын нэгж болгон архивт хүлээлгэх өгөх;</p>	<p>Яам, НЗДТГ болон харъяа газар агентлагууд</p>
<p>Ерөнхий чиг үүрэг-6: Санхүүгийн чадамжийг дээшлүүлнэ.</p>		
<p>ҮЧҮ-6: Газрын санхүүгийн үйл ажиллагааг Нягтлан бодох бүртгэлийн хууль, тогтоомжид нийцүүлэн, хэвийн үр ашигтай явуулах, удирдан зохион байгуулах, мөнгөний урсгалыг төлөвлөж зохицуулах, тайлан тэнцлээр гарсан үр дүнг тайлагнах, өмчийн зөрчилгүй байх, эд хөрөнгийн хадаглалт хамгаалалтад бүртгэлээр тавих хяналтыг сайжруулах, төсвийн хуулийн дагуу хөрөнгө оруулалтыг санхүүжүүлэх, мөн удирдлагыг санхүүгийн мэдээллээр тогтмол хангах;</p>	<p>Санхүүгийн үйл ажиллагаа болон хөрөнгө оруулалт, санхүүжилтийн явцтай холбоотой тайлан тэнцлийг хуулийн хугацаанд сар бүр гаргах</p> <p>Өмч, хөрөнгийн бүрэн бүтэн байдал, ашиглалтад хяналт тавих</p> <p>Төсөл, арга хэмжээний барилга угсралтын болон зураг төслийн ажлын гүйцэтгэлийг хянах, баталгаажуулах, санхүүжүүлэх</p> <p>Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах</p> <p>Контракт гэрээ, эдийн засгийн үр ашигийг нэмэгдүүлэх зорилтод төлөвлөгөөний биелэлтийг хангаж ажиллах, тайлагнах</p>	<p>Яам, НЗДТГ болон харъяа газар агентлагууд</p>
<p>Ерөнхий чиг үүрэг-7: Мэдээллийн ил тод, аюулгүй байдлыг ханган ажиллах</p>		
	<p>Хурал зөвөлгөөн, сургалт, олон нийтийн арга хэмжээний явцыг зурагжуулан баримтжуулж, эх бэлтгэл /брошур, баннер, постер/ хийж мэдээ мэдээлэл бэлтгэн цаг алдахгүй нийтлэх</p>	

<p>ҮЧҮ-7: Газрын хэмжээнд хэрэгжиж буй төсөл, арга хэмжээний явц, үр дүнг хэвлэл мэдээллийн хэрэгсэл телевиз радио, олон нийтийн сошиал сүлжээгээр сурталчлах, олон нийттэй харилцах,</p>	<p>Олон нийтийн мэдээллийн хэрэгслээр буруу ташаа мэдээллийг шуурхай судалж, залруулах, үнэн зөв хариу өгөх ажлыг зохион байгуулах</p>	<p>Яам, НЗДТГ болон харьяа газар агентлагууд</p>
	<p>Нийслэлийн хэмжээнд хэрэглэгддэг нэгдсэн системүүд болох Erp.ulaanbaatar.mn, open.ulaanbaatar.mn, Shilendans.gov.mn, ublegal.mn, tender.gov.mn, газрын хэмжээнд хэрэглэгддэг бүртгэл мэдээллийн систем investpro.ub.gov.mn, invest.ub.gov.mn сайтуудын хэвийн үйл ажиллагааг хангах</p>	
	<p>Газрын вэб сайтын хэвийн үйл ажиллагааг хангах, хөгжүүлэх</p>	
	<p>Цахим мэдээллийн нэгдсэн сан, мэдээллийн нэгдсэн сүлжээ, мэдээллийн системийн хэвийн үйл ажиллагаа, аюулгүй байдлыг хариуцах, мэдээллийн сангийн уялдаа холбоог хангах</p>	
	<p>Газрын бүртгэл мэдээллийн системийн хэвийн үйл ажиллагааг хангах хянах</p>	
	<p>Газрын нийт албан хаагчдын компьютерт мэргэжлийн болон хэрэглээний программ суулгах, заавар зөвөлгөө өгч, хэвийн үйл ажиллагааг хангах;</p>	
	<p>Техник хангамж, мэдээллийн сүлжээ, техник хэрэгслийн элэгдэл хорогдол, гэмтэл саатал, доголдоос сэргийлэх, хэвийн ажиллагааг хангах, гэмтэл, саатлыг тухай бүр түргэн шуурхай засварлах арга хэмжээ авах</p>	

**ДӨРӨВ. АЛСЫН ХАРАА**

“Зөвлөх үйлчилгээний чанарыг Олон улсын түвшинд хүргэсэн мэргэжлийн байгууллага болно”

**ТАВ. ЭРХЭМ ЗОРИЛГО**

“Зөв төлөвлөлт, чанартай бүтээн байгуулалт, үр дүнтэй хяналт”

**ЗУРГАА. ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭ**

**Байгууллагын дотоод орчны шинжилгээ /SWOT/**

НЭГ. ДОТООД ХҮЧИН ЗҮЙЛ	
<p><b>Давуу тал:</b></p> <ul style="list-style-type: none"> <li>✓ Төсвийн хөрөнгөөр Нийслэлд хэрэгжиж байгаа хөрөнгө оруулалтад мэргэжлийн хяналт тавьдаг байгууллага</li> <li>✓ Мэргэжлийн захиалагчийн хяналт тавих дадлага, туршлагатай, инженер техникийн ажилтнууд, удирдлагын багтай</li> <li>✓ Төсвийн хөрөнгө оруулалтын ажлыг нийгмийн эрэлт хэрэгцээнд тулгуурлан судалж, төлөвлөдөг.</li> <li>✓ Хөрөнгө оруулалт бүтээн байгуулалтын ажлыг богино хугацаанд чанартай хийж гүйцэтгүүлэхийн тулд бүсийн системээр ажиллаж байгаа</li> <li>✓ Гүйцэтгэгч байгууллагуудын хийсэн ажил, үйл ажиллагаанд зэрэглэл тогтоож дараагийн хөрөнгө оруулалтын ажилд эрсдэл гарахаас урьдчилан сэргийлдэг</li> </ul>	<p><b>Сул тал:</b></p> <ul style="list-style-type: none"> <li>✓ Хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын ажил нэмэгдэж байгаатай уялдуулан нэг хяналтын инженерт ноогдох ажлын тоо хэмжээ нэмэгддэг</li> <li>✓ Хөрөнгө оруулалтын ажлын санхүүжилт төрийн болон бусад байгууллагуудын үйл ажиллагаанаас хамаарч удааширснаар гүйцэтгэгчийн үйл ажиллагаанд шууд болон шууд бусаар нөлөөлдөг</li> <li>✓ Шууд хөрөнгө оруулалт батлагдсанаас газрын асуудалтай төсөл хөтөлбөрүүд бий болдог.</li> <li>✓ Тендер зарлах, үнэлэх, шалгаруулах хугацаа төлөвлөсөнөөс хоцорсноос хөрөнгө оруулалтын ажлын гүйцэтгэл хугацаандаа хэрэгжих боломжгүй болдог.</li> <li>✓ Бүтээн байгуулалтын ажил зөвхөн дулааны улиралд хийгддэг.</li> </ul>



<ul style="list-style-type: none"> <li>✓ Хөрөнгө оруулалтын ажлын мэдээ, мэдээллийг ил тод нээлттэй болгох зорилгоор хөрөнгө оруулалтын нэгдсэн мэдээллийн сан, программ хангамжийг тогтмол ажиллуулдаг.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>✓ Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх ажлууд нь судалгаа, шинжилгээ, зураг төсөвгүйгээр батлагддаг.</li> </ul>
---	---

**ХОЁР. ГАДААД ХҮЧИН ЗҮЙЛ**

<p><b>Боломж:</b></p> <ul style="list-style-type: none"> <li>✓ Гадаадын болон хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг татах нийслэлд хийгдэж байгаа зарим нэр төрлийн ажлуудад хяналт тавьж ажиллах</li> <li>✓ Дотоодын чадварлаг гүйцэтгэгч байгууллагууд нэмэгдэж байна</li> <li>✓ Хүйтний улиралд хийгдэж болох бүтээн байгуулалтын ажлын тоног төхөөрөмж, материал түүхий эдийн судалгаа шинжилгээ хийж, туршлага солилцох</li> <li>✓ Ажилчдынхаа нийгмийн хангамжийг сайжруулах</li> <li>✓ Ажилчдын мэдлэг, чадварыг дээшлүүлэх</li> </ul>	<p><b>Аюул занал /Саад бэрхшээл/:</b></p> <ul style="list-style-type: none"> <li>✓ Байгаль цаг уурын тааламжгүй нөхцөл байдлаас шалтгаалж төлөвлөсөн ажлын хугацаа хойшлох</li> <li>✓ Бараа, материал түүхий эдийн үнийн өсөлт</li> <li>✓ Чадваргүй гүйцэтгэгч компани зөвлөх үйлчилгээ болон, тендерт ялах</li> <li>✓ Байгууллагуудын хоорондын уялдаа холбоо муугаас ажил удааширдаг</li> <li>✓ Салбарын норм, дүрэм, стандартын өөрчлөлт орох</li> </ul>
--	---

**Байгууллагын Гадаад орчны шинжилгээ /PEST/**

Улс төрийн хүчин зүйлс	Эдийн засгийн хүчин зүйлс
<p><b>Эерэг тал</b></p> <ul style="list-style-type: none"> <li>✓ УИХ, Засгийн газрын зүгээс нийслэлд хийгдэх хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэхэд чиглэгдсэн тогтоол шийдвэрүүдийг гаргасан</li> <li>✓ УИХ-ын гишүүд, салбарын сайд нарын багцын хөрөнгөөр нийслэлд хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний тоо нэмэгдэх хандлагатай байна.</li> </ul> <p><b>Сөрөг тал</b></p> <ul style="list-style-type: none"> <li>✓ Улс төрийн тогтворгүй байдал бий болох</li> <li>✓ Зарим нэр төрлийн хөрөнгө оруулалтын зориулалт өөрчлөгдөх</li> <li>✓ Салбаруудын харилцан адилгүй хөрөнгө оруулалт</li> <li>✓ Төсвийн хөрөнгийг батлахдаа холбогдох хууль, дүрэм журмыг мөрддөггүй. Улс төрийн болон бусад нөлөөлөл орж байгаа нь төсвийн хөрөнгийг судалгаагүй, үр ашиггүй хөрөнгө оруулалтад зарцуулахад хүргэх</li> </ul>	<p><b>Эерэг тал</b></p> <ul style="list-style-type: none"> <li>✓ Төсвийн эрх мэдэл орон нутагт шилжсэн</li> <li>✓ Улсын төсвөөр нийслэлд хийгдэх хөрөнгө оруулалтын тоо нэмэгдэх хандлагатай.</li> <li>✓ Бүтээн байгуулалтын ажлыг гүйцэтгэх дотоодын компаниудын тоо, чанарын өсөлт</li> <li>✓ МУ-ын урт болон дунд хугацааны бодлогын баримт бичгүүдэд цаашид нийслэлд хэрэгжүүлэх бүтээн байгуулалтад хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх хандлагатай.</li> </ul> <p><b>Сөрөг тал</b></p> <ul style="list-style-type: none"> <li>✓ Инфляцийн өсөлт</li> <li>✓ Барилгын материал, шатахуун гэх мэт бараа материалын үнийн өсөлт</li> <li>✓ Импортын бүтээгдэхүүнээс хараат байдал</li> <li>✓ Төсвийн хязгаарлагдмал байдал</li> </ul>
Нийгмийн хүчин зүйлс	Технологийн хүчин зүйлс
<p><b>Эерэг тал</b></p> <ul style="list-style-type: none"> <li>✓ Сүүлийн жилүүдэд нийслэлд хийгдэж байгаа хөрөнгө оруулалтын ажилд өгөх үнэлгээ дээшилсэн</li> <li>✓ Бүтээн байгуулалтын ажилд ажиллах орон тоо, ажлын байр нэмэгдэж байгаа</li> </ul> <p><b>Сөрөг тал</b></p> <ul style="list-style-type: none"> <li>✓ Бүтээн байгуулалтын ажлын мэдээг албан ёсны сувгаар мэдээллээгүйгээс олон нийт ташаа ойлголт авдаг.</li> </ul>	<p><b>Эерэг тал</b></p> <ul style="list-style-type: none"> <li>✓ Техник, технологийн орчин үеийн дэвшилтэт тоног төхөөрөмж, материалыг бүтээн байгуулалтанд нэвтрүүлэх болсон</li> <li>✓ Технологийн орчин үеийн дэвшилтэд тоног төхөөрөмж, материал хэрэглэх нь бүтээн байгуулалтын чанарыг сайжруулсан.</li> </ul> <p><b>Сөрөг тал</b></p> <ul style="list-style-type: none"> <li>✓ Техник технологийн манай улсын цаг агаар, орчин нөхцөлд зохицох чадвар</li> <li>✓ Орчин үеийн техник технологийн үнэ өндөр</li> </ul>

Хэлтсүүдийн гадаад, дотоод орчны шинжилгээ /SWOT/

Хэлтсүүд	Давуу тал	Сул тал	Боломж	Тулгамдаж буй асуудал
Төлөвлөлт судалгааны хэлтэс	<p>- Хөрөнгө оруулалтын ажлын сүүлийн 10 жилийн нэгдсэн мэдээллийн сантай болсон</p> <p>- Хөрөнгө оруулалтын хэрэгцээ шаардлагын судалгааг салбар бүрээр хийх чадвартай</p> <p>- Хөрөнгө оруулалтын судалгааг мэргэжлийн өндөр түвшинд зохион байгуулах чадвар, туршлагатай.</p> <p>-Дүүрэг, хороодтой байнгын хамтран ажилладаг.</p> <p>- Нийслэлд сонгогдсон УИХ-ын гишүүн, НИТХ-ын төлөөлөгчдөд тогтмол мэдээлэл хүргүүлж хамтран ажилладаг.</p>	<p>-Нийслэл болон холбогдох байгууллагууд хөрөнгө оруулалтын судалгаа, төлөвлөлтийг анхаардаггүй</p>	<p>-Залуу туршлагатай боловсон хүчинтэй.</p> <p>-Нийслэлд хэрэгжүүлж буй төсөл, хөтөлбөр, судалгааны ажлуудыг хийх бүрэн боломжтой.</p>	<p>-Хөрөнгө оруулалтын төлөвлөлт, судалгааг үнэлэгдэхүйц болгох.</p>
Зураг төслийн хэлтэс	<p>-Улс, Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих төсөл арга хэмжээний зураг төсөлд хяналт тавьснаар тухай төслийг чанарын өндөр түвшинд гүйцэтгэх боломжийг бий болгодог</p>	<p>-Мэргэжил арга зүйн зөвөлгөөг хэрэгжүүлж хяналт тавихад чиглэл бүрийн инженер дутмаг байдаг</p>	<p>-Нийслэлд хэрэгжих хөрөнгө оруулалтын ажлуудын зураг төсвийг хийж гүйцэтгэх</p>	<p>-Чиглэлийн инженер дутмаг, цахилгааны инженер, ус хангамж, ариутгах татуургын инженер, мэргэшсэн төсөвчин нэмэх</p>
Барилга захиалагчийн хэлтэс	<p>-Улс, Нийслэлийн төсөв, гадаадын зээл тусламжийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих төсөл, арга хэмжээний гүйцэтгэлд захиалагчийн техник хяналтын чиг үүргийг хэрэгжүүлснээр барилгын ажлыг зохих зөвшөөрөл, зураг төсөл, стандарт,</p>	<p>-Барилга угсралтын үйл ажиллагаа явуулах технологийн хугацаа богино, зураг төсөвгүй төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр төсөвт баталдаг, тендер шалгаруулалт оройддог, чадваргүй</p>	<p>-Монгол улс, Улаанбаатар хотын өсөн нэмэгдэж буй эдийн засгийн байдал, түүнийг дагасан хөрөнгө оруулалтын зардал</p> <p>-Нийслэлд амьдарч буй иргэдийн хэрэгцээ шаардлагыг хангах хөрөнгө оруулалтыг</p>	<p>-Захиалагчийн техник хяналтын чиг үүргийг хэрэгжүүлэх Барилгын тухай хууль, Захиалагчийн дүрмийн шаардлагыг хангах ажлын дадлага, туршлага бүхий бүрэлдэхүүнийг бий болгож, инженерүүдийг чадавхижуулах.</p> <p>-Дүүрэг бүрт хийгдэх хөрөнгө оруулалтын хэмжээ, төсөл, арга</p>

	<p>техникийн нөхцлийн дагуу гүйцэтгүүлж, хөрөнгө оруулалтын өгөөжийг дээшлүүлж, санхүүгийн эх үүсвэрийг үр ашигтай зарцуулах нөхцлийг бүрдүүлдэг.</p>	<p>гүйцэтгэгч сонгон шалгаруулдаг зэргээс шалтгаалж тухайн жилд батлагдсан төлөвлөгөөтэй уялдуулан гүйцэтгэлийг хангуулахад хүндрэл үүсдэг.</p>	<p>гадаадын зээл тусламжаар бий болгож буй байдал</p>	<p>хэмжээний тооноос хамаарч инженерүүдийн ачаалал харилцан адилгүй байгааг тэнцвэржүүлэх</p>
<p>Захиргааны хэлтэс</p>	<p>- Ажлын туршлага, багаар ажиллах чадвартай - Байгууллагын дотоод зохион байгуулалт үйл ажиллагааны үр дүн тус хэлтсээр дамжигдан илэрхийлэгдэж байдаг</p>	<p>-Ажиллах орчин үеийн техник хэрэгсэлээр бүрэн хангагдаагүй</p>	<p>-Ажилчдынхаа нийгмийн хангамжийг сайжруулах үйл ажиллагаа зохион байгуулах -Мэдлэг, чадварыг дээшлүүлэх сургалт</p>	<p>-Хэлтсүүд мэдээ тайлан болон хугацаатай үүрэг даалгаварын биелэлтүүдийг хугацаанд нь өгдөггүй, чирэгдүүлдэг -Олон нийтийн арга хэмжээнд оролцох оролцоо идэвхи санаачилга сул</p>
